



## ТАХЬКО (ХК) КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

211238 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Ж.Самбуугийн гудамж-18, УБД 9010001029  
Утас: 976-11-324738, Факс: +976-11-325051  
И-мэйл: info@takhico.mn, Веб хуудас: www.takhico.mn

2024.03.19 № 07

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Хурлын зар нийтлүүлж,  
мэдээлэх тухай

Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн дугаарт дараахь байдлаар нийтэлж өгөхийг хүсье.

### ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Тахько (ХК) компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал **2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 10:00 цагаас** тус компанийн байр (Чингэлтэй дүүрэг, 5 дугаар хороо, МА-III барилга буюу Анкор төвийн хурлын заал)-нд болох тул эрхэм хувьцаа эзэмшигчид та бүхнийг хуралдаа оролцохыг урьж байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараахь асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

1. Тахько (ХК) компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Тахько (ХК) компанийн 2023 оны жилийн тайлан тэнцэлд ээлжит аудит хийсэн компанийн аудиторын дүгнэлтийг танилцуулах;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох, дотоод ажлын зардлын төсвийг батлах зэрэг асуудлыг хэлэлцэнэ.

Хувьцаа эзэмшигчдийг 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс 4 дүгээр сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд ажлын цагаар өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компани болон компанийн байрны 308 тоот өрөөнд ирж хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөлтэй танилцаж, саналаа өгөхийг урьж байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг **2024 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөр**, хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүлээж авах сүүлчийн хугацааг 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 12:00 цагаар тус тус тогтоосон болно.

Хурал зохион байгуулахтай холбоотой асуудлаар хурал зохион байгуулах комиссын дарга Л.Буянбат (утас: 99113624, е-мэйл: [takhico@gmail.com](mailto:takhico@gmail.com)), комиссын гишүүн Л.Энхнасан (утас: 99118419, е-мэйл: [lenkusha@yahoo.com](mailto:lenkusha@yahoo.com)), комиссын гишүүн Ш.Мөнх-очир (утас: 99113181, е-мэйл: [munkhochir\\_sh@yahoo.com](mailto:munkhochir_sh@yahoo.com)) нартай ажлын өдрийн 10:00-13:00, 14:00-17:00 цагийн хооронд хандаж болно.

### ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА



Л.БУЯНБАТ